




МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ



2019 оны 9 сар



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК



МОНГОЛБАНК
МОНГОЛ УЛСЫН ТӨВ БАНК

Мөнгө угаах гэж юу вэ?

4

Терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ?

6

Олон улсын мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо

8

Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо

10

МУТС-тэй тэмцэх тогтолцоог үнэлэх харилцан үнэлгээ гэж юу вэ?

14

Монгол улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны өнөөгийн нөхцөл байдал

16

Санхүүгийн мэдээллийн алба /СМА/

19

Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаа гэж юу вэ?

20



Мөнгө угаах гэдэг нь гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлогыг буюу хууль бус эх үүсвэрийг нуун дарагдуулахын тулд хэлбэр, төрхийг хувиргаж, эзэмшигчийг нь өөрчлөн хуулийн ёсны хөрөнгө, орлого шиг харагдуулах төрөл бүрийн арга хэрэгсэл ашиглах үйл ажиллагаа юм.

Мөнгө угаах нь ихэвчлэн дараах үндсэн зорилготой байдаг. Үүнд:

- Хууль бус эх үүсвэрээс олсон орлого, эд хөрөнгийг өөрчлөн, шилжүүлэх;
- Хууль бус эх үүсвэрээс олсон орлого, эд хөрөнгө болон эзэмшигчийг нь нуун далдлах;
- Хууль бус эх үүсвэрээс олсон орлого, эд хөрөнгийг олж авах, эзэмших, ашиглах үр шимийг нь хүртэх;
- Мөнгө угаах гэмт хэргийг үйлдэхэд оролцох, хамтрах, зөвлөгөө өгөх гэх мэт.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь байршуулах (placement), далдлах (layering-олон давхарга үүсгэх), нэгтгэх (integration) гэсэн гурван үе шаттай үйлдэгддэг. Зураг 1-т эдгээр үе шатны зорилго, ашиглаж буй арга хэрэгсэл, сувгийг товчхон дурдав.

Мөнгө угаах үйл ажиллагаанд санхүүгийн салбарын нарийн мэргэшсэн мэргэжилтнүүдээс гадна хуулийн этгээд, санхүүгийн бус мэргэжлийн үйлчилгээ бизнес эрхлэгч, нягтлан бодогч, хуульч, халхавч компани, зуучлагч ашиглаж гүйлгээ хийх нь түгээмэл байдаг тул уг гэмт хэрэгтэй тэмцэх, хууль бус хөрөнгийг илрүүлэхэд олон салбар хамарсан өргөн хүрээний мэдлэг шаардагддаг. Мөнгө угаагчид гэмт хэргийн улмаас олсон хөрөнгөө хувиргаж болох дэлхийн зах зээл, дотоодын зах зээл дэх хэрэглээнд нэвтэрч буй төлбөр тооцооны хэрэгслүүд, өндөр өртөгтэй хөрвөх чадвартай үнэт металл, үнэт эдлэл, бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэхийг завдаж байдаг.

Зураг 1. Мөнгө угаах үйл ажиллагааны үе шатууд



- 1. Байршуулах үе:** гэмт хэргийн улмаас олсон орлого, хөрөнгийг хууль ёсны санхүүгийн системд байршуулах, мөнгөн тэмдэгтийг өөр дэвсгэрт, гадаад валютаар солиулах, бэлэн мөнгө тээвэрлэх, бэлэн мөнгийг банкны дансанд байршуулах г.м.
- 2. Далдлах үе:** хууль бус, гэмт хэргийн гаралтай хөрөнгө, орлогын гарал үүслийг нуун дарагдуулах зорилгоор бэлэн бус шилжүүлэг хийх, өөр банкны дансанд байршуулах, банк хооронд салгаж, нийлүүлж шилжүүлэх, олон банк, улс орнуудаар дамжуулан эх үүсвэрийг нуун далдлах г.м.
- 3. Буцааж нэгтгэх үе:** гэмт хэргийн улмаас олсон орлогын гарал үүслийг нь нуун далдалсан хөрөнгө, орлогоо хууль ёсны болгож харагдуулах халхавч зээлийн гэрээ хийх, хуурамч борлуулалт болон гэрээ хийх, худалдааны тайлан гаргах, санхүүгийн тайлан гаргах, **хөрөнгийн эцсийн/жинхэнэ өмчлөгчийг** нуун дарагдуулах гуравдагч этгээдийг гүйлгээнд ашиглах, үнэтэй хөрөнгө, үл хөдлөх хөрөнгө, тансаг зэрэглэлийн машин, онгоц худалдан авах, хөрөнгө оруулалт хийх г.м.



Терроризмыг санхүүжүүлэх гэдэг нь терроризм үйлдэхээр санаархаж, төлөвлөж эсхүл оролцох гэж буй хувь хүн, байгууллага болон бусад этгээдэд зориулан хууль ёсны болон хууль бус хөрөнгө, орлогыг хуримтлуулах, шилжүүлэх, зарцуулах үйл ажиллагаа юм.

Терроризмыг ихэвчлэн дараах эх үүсвэрээс олсон орлогоор санхүүжүүлдэг. Үүнд:

- Их хэмжээний эд хөрөнгө хулгайлах;
- Хар тамхи, зэвсгийн наймааны хууль бус худалдаа явуулах;
- Хууль бус цагаачлал болон хүн худалдаалах;
- Хүн барьцаалах, хулгайлах;
- Айлган сүрдүүлэх;
- Хууль ёсны болон хууль бус орлогоос хандив тусламж өгөх (хувь хүн, төрийн бус байгууллага, хүмүүнлэгийн байгууллага).

Мөнгө угаах нь хууль бус, гэмт хэргийн гаралтай хөрөнгийг хууль ёсны салбараар дамжуулан хууль бус гарал үүслийг нууж эцсийн үр шимийг хүртэх шунахайн сэдэлтэй үйлдэгддэг бол терроризмыг санхүүжүүлэх нь хууль ёсны эсхүл хууль бусаар олсон хөрөнгийн эх үүсвэрийг далдалж террорист үйл ажиллагааг

санхүүжүүлэх зорилгоор үйлдэгддэг. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх нь мөнгөний гарал үүсэл, зорилго, сэдлээрээ ялгаатай ч мөнгөний эх үүсвэрийг нуун далдлах, хувиргах болон байршуулах арга хэлбэрээрээ ижил төстэй.





Мөнгө угаах гэмт хэрэг, түүний үр дагавар

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх нь зөвхөн дэлхийн том санхүүгийн төв болон оффшор бүсийн асуудал биш бөгөөд хөгжиж байгаа улсуудад ч хамаатай хэрэг юм. Учир нь хөгжиж байгаа улс орнуудын эдийн засаг, санхүүгийн салбар нээлттэй болохын хэрээр эдгээр үйл ажиллагаанд өртөх эрсдэл улам нэмэгддэг. Мөн өндөр хөгжилтэй улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа чангарахын хэрээр мөнгө угаагч нар өөр улс орон, хөгжиж байгаа улсууд руу анхаарлаа хандуулах болсон.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа нь улс орны санхүүгийн салбарын цогц байдал болон

тогтвортой байдалд нөлөөлж нийт эдийн засаг, улс орны хөгжил гадаад нэр хүндэд нөлөөлж, олон улсын санхүүгийн системд сөрөг үр дагаврыг үзүүлэх эрсдэлтэй байдаг.

Гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, орлого нь санхүүгийн системийг санхүүгийн урсгалыг тогтворгүй болгож, санхүүгийн салбарын хямрал үүсгэх нөхцөл болж, татварын орлого цуглуулалтад нөлөөлж, төр засгийн бодлогыг сулруулж, санхүүгийн байгууллагуудын нэр хүнд, гадаадын кореспондент банкны харилцаанд нөлөөлдөг. Өөрөөр хэлбэл мөнгө угаах нь мөнгөний эрэлтэд шалтгаангүйгээр нөлөөлж, гадаад хөрөнгийн урсгал, хүү, ханш тогтворгүй болж, эдийн засаг, санхүүгийн бодлогын арга хэрэгслийн үйлчлэл суларч зорилгодоо хүрэх боломжгүй болно.

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээ авах байгууллага (Financial Action Task Force буюу ФАТФ) нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсгийг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх, дэлхийн санхүүгийн системийг хамгаалах бодлогыг боловсруулж дэлгэрүүлэх үүрэг бүхий засгийн газар хоорондын хараат бус байгууллага юм. ФАТФ-аас гаргасан зөвлөмж нь дэлхий нийтийн мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандарт гэж хүлээн зөвшөөрөгддөг. ФАТФ нь Их долоогийн уулзалтаар 1989 онд байгуулагдсан. Одоогоор 35 өндөр хөгжилтэй улс, 2 бүс нутгийн холбооны гишүүдтэй бөгөөд бүс нутгийн байгууллагуудаар дамжуулан үйл ажиллагаагаа хэрэгжүүлдэг.

1997 онд байгуулагдсан Ази, Номхон далайн бүсийн байгууллага (The Asia/Pacific Group on Money Laundering буюу АНДББ) нь ФАТФ-ын төрлийн, бүс нутгийн хэмжээнд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх (МУТСТ) үйл ажиллагааг зохицуулах байгууллага бөгөөд Монгол Улс 2004 онд гишүүнээр нь элссэн билээ.

Эцэст нь мөнгө угаах гэдэг асуудал




ОЛОН УЛСЫН МӨНГӨ УГААХ ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО



нь дэлхий нийтэд тулгамдаж байгаа өдөр тутам өөрчлөгдөж байдаг анхаарал хандуулах шаардсан цогц асуудал юм. Үүнтэй тэмцэхэд дэлхий нийтийн стандарт, олон улсын хамтын ажиллагаа хүчин чармайлт хэрэгтэй.

Ийм ч учраас ФАТФ- аас гаргасан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх 40 зөвлөмж (International standards on combating money laundering and the financing of terrorism & proliferation)-ийг улс орон бүр биелүүлэх үүрэгтэй. Энэ зөвлөмжийн биелэлтийг ФАТФ-ын бүсийн байгууллагаас тодорхой давтамжтайгаар харилцан үнэлж тайлан гаргадаг. Харилцан үнэлгээний тайлангийн дүгнэлтээр тухайн улс нь 40 Зөвлөмжийг биелүүлэх хүсэл сонирхолгүй эсвэл биелүүлэхээс татгалзвал тухайн улс орныг өндөр эрсдэлтэй гэж дүгнэн “саарал” болон “хар жагсаалт”-д оруулж анхааруулах арга хэмжээ авдаг.

БАНК
ӨВ БАНК



Монгол Улс 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль баталснаар Санхүүгийн мэдээллийн алба (СМА)-ыг байгуулж, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг эхлүүлэх суурийг тавьсан.

2013, 2018 онд энэ хуульд нэмэлт өөрчлөлт оруулснаар хуулийн хамрах хүрээг өргөжүүлж, олон улсын стандарт, шаардлагын дагуу мэдээлэх үүрэгтэй этгээдээр үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, үнэт металл, үнэт чулуу, тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч, нотариатч, хуульч, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийг нэмсэн. Ийнхүү дээрх мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлж, харилцагчийг таньж мэдэх, гүйлгээ эсхүл үйл ажиллагааны мэдээллийг СМА-нд мэдээлэх үүрэг, хариуцлага хүлээж байна. Үүнд:

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 4 дүгээр зүйл: Мэдээлэх үүрэгтэй этгээд:

4.1.1.банк;

4.1.2.банк бус санхүүгийн байгууллага;

4.1.3.даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч;

4.1.4.хөрөнгө оруулалтын сан, хөрөнгө оруулалтын менежментийн компани;

4.1.5.үнэт цаасны зах зээлд оролцогч мэргэжлийн байгууллага;

4.1.6.хадгаламж, зээлийн хоршоо;

4.1.7.харилцагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө худалдан авах, эсхүл худалдах аливаа ажиллагаа явуулсан бол үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага;

4.1.8. энэ хуулийн 5.1.2-т заасан мөнгөн дүн бүхий бэлэн мөнгөний гүйлгээ хийсэн бол үнэт металл, үнэт чулууны, эсхүл тэдгээрээр хийсэн эдлэлийн арилжаа эрхлэгч;

4.1.9.нотариатч, хуульч, эсхүл нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн менежментийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь харилцагчийн нэрийн өмнөөс дараах ажиллагааг хийсэн бол:

4.1.9.а.үл хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах;

4.1.9.б.харилцагчийн хөрөнгийг удирдах;

4.1.9.в.банкны, хадгаламжийн, үнэт цаасны дансыг удирдах;

4.1.9.г.компанийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах,

МОНГОЛ УЛСЫН МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦОО



удирдахад зориулан хөрөнгө татах, бүрдүүлэхийг зохион байгуулах;
4.1.9.д.хуулийн этгээдийг үүсгэн байгуулах, түүний үйл ажиллагааг явуулах, удирдах, эсхүл хэлцлийн үндсэн дээр аливаа тодорхой үйл ажиллагаа явуулах, удирдах, эсхүл аж ахуйн нэгжийг худалдах, худалдан авах.

Эдгээр мэдээлэх үүрэгтэй этгээд нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу дараах мэдээллийг мэдээлэх үүрэгтэй. Үүнд:

1. 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний гүйлгээ;
2. 20 сая төгрөг /түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валют/ буюу түүнээс дээш үнийн дүнтэй гадаад төлбөр тооцооны гүйлгээ;
3. мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй, эсхүл гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлоготой холбоотой гэж сэжиглэсэн хөрөнгө, гүйлгээ, гүйлгээ хийх оролдлого бүхий сэжигтэй гүйлгээ /дүн харгалзахгүй/.

Мэдээлэх үүрэгтэй этгээдийн харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, гүйлгээ, үйл ажиллагааны мэдээллийг хуульд заасан хугацаанд мэдээлэх, холбогдох гүйлгээнд өндөржүүлсэн хяналт хэрэгжүүлэх, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих, хэрэгжилтийг хангуулах ажлыг Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл

олгох, хяналт тавих эрх бүхий байгууллага гэсэн 3 төрлийн байгууллага эрсдэлд суурилсан хэлбэрээр хэрэгжүүлнэ. / Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 19 дүгээр зүйл/, / Бүдүүвч 2/

Бүдүүвч 2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хяналт шалгалт хийх үйл ажиллагаа



**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
тухай хууль, 23 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид
хүлээлгэх хариуцлага**

23.1.Энэ хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд холбогдох хуульд заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

23.2.Энэ хууль, хуульд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нь хяналт шалгалтаар тогтоогдсон, тусгай зөвшөөрлийн шаардлагыг хангаагүй нь гэмт хэрэг, зөрчлийн шинжгүй бол энэ хуулийн 19.1-д заасан байгууллагын эрх бүхий албан тушаалтан үүссэн нөхцөл байдал, дутагдлыг харгалзан дараах арга хэмжээг авна:


23.2.1.дутагдлыг арилгах талаар албан шаардлага тавьж, сануулга өгөх, хугацаатай үүрэг, даалгавар өгөх;

23.2.2.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтыг сайжруулж, бэхжүүлэх арга хэмжээ авахыг даалгах;

23.2.3.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, зогсоох, түдгэлзүүлэх, үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал гаргах;

23.2.4.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн эрх бүхий албан тушаалтныг албан тушаалаас чөлөөлөх, түдгэлзүүлэх, өөрчлөхийг үүрэг болгох.

23.3.Эрх бүхий албан тушаалтнаас энэ хуулийн 23.2-т заасны дагуу өгсөн хугацаатай үүрэг, даалгавар, сануулга, шаардлагыг биелүүлээгүй бол Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.





ФАТФ-аас гишүүн орнуудын 40 зөвлөмжийн хэрэгжилтийн түвшинг үнэлэх зорилгоор ФАТФ-тэй төстэй бүс нутгийн байгууллагуудаар дамжуулан байнгын хяналт тавьдаг байна. Гишүүн орнуудын төлөөллөөс бүрдсэн үнэлгээний баг зөвлөмжийн хэрэгжилтийг нарийн үнэлж, тайлан гаргадаг бөгөөд тус дүгнэлтэд үндэслэн цаашид авах арга хэмжээний чиглэлийг тодорхойлдог байна. Үнэлгээний баг ФАТФ-ын батлагдсан аргачлалын дагуу үнэлгээг хийж гүйцэтгэнэ. Одоогоор 2013 онд ФАТФ-аас боловсруулсан үнэлгээний аргачлалыг ашиглаж байгаа ба энэхүү аргачлалаар зөвлөмжийн техникийн хэрэгжилтийг үнэлэхээс гадна, зөвлөмжийн үр дүнтэй байдлын үнэлгээг хийж, дүгнэлт өгдөг болсон.

Техникийн хэрэгжилт гэдэг нь ФАТФ-

ын 40 зөвлөмж тухайн улсын хууль, журамд тусгагдсан эсэхийг үнэлдэг бол харилцан үнэлгээний чухал хэсэг болох үр дүнтэй байдал гэдэг нь ФАТФ-ын зөвлөмж бодит байдал дээр хэрхэн хэрэгжиж буйг үнэлж, дүгнэдэг байна. ФАТФ-ын өмнөх туршлагаас зөвхөн техникийн хэрэгжилтийг шалгах нь хангалтгүй гэж үзсэн учраас үр дүнтэй байдлын үнэлгээнд илүү анхаарлаа хандуулан үнэлгээг хийж байна.

ФАТФ –ын “хар”, “саарал жагсаалт” жагсаалтад орохын хор үршиг нь:

- Олон улсын байгууллагууд хамтран ажиллахаас татгалзах,
- Гадаадын харилцагч банкууд харилцаагаа таслах, нэмэлт мэдээлэл шаардах,
- Гадаадын хөрөнгө оруулалт зогсох, гадаад худаддаа багасах,
- Тухайн жагсаалтанд орсон улс орны

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООГ ҮНЭЛЭХ ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

иргэд гадаад улсад картаар гүйлгээ хийх боломжгүй болох,

- Гадаад шилжүүлгийн гүйлгээг хийх хүндрэлтэй болох, нэмэлт мэдээлэл шаардах, шалгах давтамж ойртох, гүйлгээ буцаах, гүйлгээ хийх хугацаа уртсах,
- Улмаар эдийн засаг агших, ард түмний амжиргаа доройтох зэрэг байдаг.
- Тухайлбал, Иран болон Хойд Солонгос улсыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо хангалтгүй, олон улсын санхүүгийн системд ноцтой аюул заналхийлэл учруулж байгаа гэж үзэн “хар жагсаалт”-д оруулсан бол стандартыг хангалтгүй хэрэгжүүлж буй хэд хэдэн улсуудыг (жишээлбэл, Багамын арлууд, Ботсвана, Этиопи, Гана, Пакистан, Серб, Шри-Ланка, Сири, Тринидад Тобаго, Тунис, Иемен) “саарал жагсаалт”-д оруулж тогтолцоог сайжруулахыг шаардсан байна. Өмнө нь Ирак, Вануату улсыг 2018 оны 6 дугаар сард ФАТФ-ын мэдэгдлээр саарал жагсаалтаас гаргасан байна. Учир нь тус улсууд МУТС-тэй тэмцэх

тогтолцоог сайжруулах үүрэг амлалтаа биелүүлж, сайжруулсан байна. Өөрөөр хэлбэл, Ирак, Вануату улсад мөнгө угаах, хууль бус орлоготой тэмцэх тогтолцоо хэрэгжиж эхэлсэн байна. Ингэснээр хууль бусаар олсон орлогоо Ирак, Вануату дамжуулан нуун далдлах боломж тодорхой хэмжээнд хаагдаж байна гэж ойлгож болно. (2019 оны 5 дугаар сар, ФАТФ-ын цахим хуудас).


- Улс орнуудыг МУТС-тэй тэмцэх хоригийн жагсаалтаас гарсан эсэхээр нь шууд дүгнэхэд хэтэрхий өрөөсгөл ойлголт юм. Учир нь гэмт хэргийн бүлэг болон тэдгээрийн арга хэрэгсэл улам нарийсан сүүлийн үеийн шилдэг техник технологийг ашиглан хийгдэж байдаг болохоор МУТС-тэй тэмцэх тогтолцоог мөн байнгын хөгжүүлж, сайжруулж байх шаардлага бий болсон. Тиймээс улс орнууд МУТС-тэй тэмцэх тогтолцоог олон улсын стандартад нийцүүлж, байнга сайжруулж байж энэ төрлийн гэмт хэрэгтэй үр дүнтэй тэмцэнэ.

Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн

арга хэмжээ авах байгууллага болох ФАТФ-ын Ази, Номхон далайн бүсийн байгууллага /АНДББ/-аас Монгол Улсын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны анхны үнэлгээг 2007 онд зохион байгуулсан, энэ Харилцан үнэлгээний тайланд Монгол улс ФАТФ-ын 49 шалгуураас 21 биелүүлээгүй, 15 хэсэгчлэн биелүүлсэн гэсэн маш муу үнэлгээ авч байсан. Энэ үр дүнгээс шалтгаалан 2011 онд Олон улсын хамтын ажиллагааг хянах бүлэг (International Cooperation Review Group буюу ОУХАХБ)-ээс Монгол Улсын мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог өөрийн хяналтад оруулахаар болж улмаар 2013 онд Монгол Улс ФАТФ-ын “саарал жагсаалт”-д орж байсан. Тухайн үед Монгол Улсын эдийн засаг өндөр өсөлттэй байсан, гадаад нэр хүнд сайн байсан зэрэг шалтгаанаас эдийн засагт учруулсан бодит хохирол бага байсан. Монгол Улсын Улсын Их Хурал, Засгийн газраас шуурхай арга хэмжээ авч Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулан холбогдох журам, зааврыг богино хугацаанд батлуулсаны үр дүнд 2014 оны 6 дугаар сард энэ жагсаалтаас хасагдаж байсан. АНДББ-аас Монгол Улсын мөнгө

угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцооны хоёр дахь удаагийн үнэлгээг 2016-2017 онд хийж 2017 оны 7 дугаар сард хуралдсан АНДББ-ын жилийн чуулганы үеэр Монгол улсын харилцан үнэлгээний тайланг хэлэлцэж, Монгол Улсыг “эрчимтэй хяналтад” оруулах шийдвэр гаргасан байна. Тухайн хоёр дахь удаагийн харилцан үнэлгээний онцлог нь техникийн хэрэгжилттэй холбоотой ФАТФ-ын 40 зөвлөмжийн биелэлтийг төдийгүй үр дүнтэй байдлын 11 үзүүлэлтийг/2013 оноос 40 зөвлөмж мөн 11 үр дүнтэй байдлын үзүүлэлтээр үнэлдэг болсон/ үнэлж дүгнэсэнд оршино.

Зураг 1. Монгол Улсын Техникийн хэрэгжилтийн үнэлгээ
Эх сурвалж: APG, Харилцан үнэлгээний




тайлан, 2017 оны 9-р сар
Харин “Үр дүнтэй байдал”-ын хувьд

МОНГОЛ УЛСЫН МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ ТЭМЦЭХ ТОГТОЛЦООНЫ ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

11-ээс 2 шалгуурыг хэрэгжүүлэх түвшин дунд зэргийн үр дүнтэй, 9 шалгуур бага үр дүнтэй гарсан байна.

Зураг 2. Монгол Улсын Үр дүнтэй байдлын үнэлгээ

Эх сурвалж: APG, Харилцан үнэлгээний



тайлан, 2017 оны 9-р сар

ФАТФ-ын саарал жагсаалтад орохгүй байхын тулд техникийн хэрэгжилтийн хувьд “дийлэнхийг хангасан” болон “бүрэн хангасан” зөвлөмжийн тоог хамгийн багадаа 21-д, харин үр дүнтэй байдлын хувьд хамгийн багадаа 6-7 үзүүлэлтийг “дунджаас дээш” үнэлгээнд хүргэх шаардлага байгаа юм.

Монгол Улс энэхүү үүргийг хангалтгүй

биелүүлэх аваас “эрчимтэй хяналт”-аас ФАТФ-ын “саарал жагсаалт”-ад шилжих эрсдэлтэй тулгарна. “Саарал жагсаалтад” орох нь санхүүгийн системд, улмаар нийт эдийн засагт ноцтой эрсдэл учруулах эрсдэлтэй юм. Тухайлбал, Монгол улсын зээлжих зэрэглэл буурах, гадаад зах зээлээс хөрөнгө босгох боломж хумигдах, ААН-үүдийн хөрөнгө татах зардал нэмэгдэх, банкуудын гадаад гүйлгээ зогсох, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ ханш өсөх зэрэг үр дагаварыг дагуулж болно. Монгол улс өмнө нь саарал жагсаалтад орж байсан үетэй харьцуулахад ДНБ-ий хэмжээ үлэмж нэмэгдсэн, эдийн засгийн гадаад харилцаа ихээхэн тэлсэн тул энэ удаа саарал жагсаалтад орох нь хавьгүй ноцтой сөрөг үр дагаварт хүргэж болзошгүй юм.

Монгол Улс “эрчимтэй хяналтаас” үүдэж болох сөрөг үр дагавараас зайлсхийх, санхүүгийн гэмт хэргээс эдийн засгаа хамгаалах, корреспондент банкуудтай харилцах харилцааг алдахгүй байх нь өнөөдөр тулгамдсан асуудал болоод байна.

Иймд үлдэж буй хугацаанд Монгол Улс АНДББ, ФАТФ-тай идэвхтэй хамтран ажиллаж, “саарал жагсаалт”-д орохгүйн



тулд шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажилах хэрэгтэй.

Дээрх нөхцөл байдлыг ойлгож дараах эрх бүхий байгууллагууд нь "Хамтын ажиллагааны зөвлөл" болон "Үндэсний зөвлөл" (Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Терроризмтой тэмцэх ажиллагааг зохицуулах зөвлөл, Улсын ерөнхий прокурорын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар) байгуулан ажиллаж байна.

Монгол улсын Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоог сайжруулах, цаашлаад саарал жагсаалтаас гаргах эсэх нь дан ганц Санхүүгийн мэдээллийн албаны үүрэг биш бөгөөд дээрх байгууллагуудын хамтын ажиллагаанаас шууд хамаарах юм.

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн дагуу мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Санхүүгийн мэдээллийн алба (СМА) Монголбанкны дэргэд байгуулагдан үйл ажиллагаа явуулж байна.

Санхүүгийн мэдээллийн алба нь:

1. Мэдээлэх үүрэгтэй этгээдээс мэдээлэл хүлээн авах, мэдээллийн сан бүрдүүлэх, дүн шинжилгээ хийх;

2. Мэдээллийг төрийн эрх бүхий байгууллагад шилжүүлэн шалгуулах;

3. Сэжигтэй гүйлгээг илрүүлэх, хянах аргачлал боловсруулж мэдээлэх үүрэгтэй этгээдэд мэдээлэх, хэрэгжилтийг зохион байгуулах;

4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар олон нийтийн дунд мэдээлэл, сурталчилгаа явуулах;

5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн хяналт шалгалтын талаар нэгдсэн статистик гаргах, хяналт шалгалт хийх, эрх бүхий бусад этгээдээр хяналт шалгалт хийлгэх;

6. Гадаад, дотоодын болон олон улсын байгууллагуудтай хууль тогтоомжийн

хүрээнд хамтран ажиллах чиг үүрэгтэй байгууллага юм.

Монгол Улс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх сайн тогтолцоо, сайтар бэхжсэн Санхүүгийн мэдээллийн албатай байснаар гэмт этгээдүүд манай банк, санхүүгийн байгууллагуудыг ашиглах, тэдний нэр хүндийг олон улсын тавцанд унагаахаас урьдчилан сэргийлэх боломжтой.



Харилцагчийг таньж мэдэх гэдэг нь харилцагчийг тодорхойлох мэдээллийг харилцагчаас гаргуулж авах бөгөөд хэнийг төлөөлж байгаа, ямар үйл ажиллагаа авуулдаг, ямар зорилгоор харилцаж байгаа зэрэг мэдээллийг тодруулах, тухайн мэдээллийн үнэн зөвийг тогтоох зорилгоор албан ёсны бичиг баримт, төрийн байгууллагын мэдээллийн сан болон мэдээллийн бусад эх үүсвэрийг ашиглан мэдээллийг баталгаажуулах үйл ажиллагааг хэлнэ. Энэ нь харилцагчийн болон түүний төлөөлж байгаа этгээдийн эцсийн өмчлөгч, харилцагчийн бизнесийн үр шим хүртэгч этгээд, удирдах эрх бүхий этгээдийг тодорхойлох, мэдээллийг баталгаажуулах зорилготой юм.

Яагаад харилцагчийг таньж мэдэх шаардлагатай вэ?

Харилцагчийг таньж мэдэх зорилго гэдэг нь санхүүгийн байгууллага нь харилцагч таны мэдээлэлд үндэслэн өөрийн тань санхүүгийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, хангахаас гадна мөн харилцагчийн орлого, мөнгөн хөрөнгө нь хууль ёсны бөгөөд аливаа гэмт хэргийн улмаас олсон мөнгийг угаах болон терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа эрхлэх эрмэлзэлгүй болохыг



ХАРИЛЦАГЧИЙГ ТАНЬЖ МЭДЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ГЭЖ ЮУ ВЭ?



баталгаажуулахад оршино.

Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагаанд оролцох харилцагч таны үүрэг Харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцад иргэн болон хуулийн этгээдүүд дараах үүргийг хүлээнэ:

- Тухайн санхүүгийн байгууллагын дүрэм журмыг биелүүлэх;
- Санхүүгийн байгууллагаас шаардсан мэдээллийг шуурхай гаргаж өгөх;
- Үнэн зөв мэдээллээр хангах;

Харилцагч та дээрх хуульд заасан үүргээ биелүүлсэнээр Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоонд хувь нэмэрээ оруулж байгаа юм.





976-11-310081



<https://www.mongolbank.mn>



<https://www.youtube.com/user/mongolbankmn>



https://twitter.com/Mongolbank_mn



<https://www.facebook.com/Mongolbank.mn>